



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 6 дугаар
сарын 6-ны өдөр

Дугаар 306


Улаанбаатар
хот

Авто замын барилгын ажлын талаар авах
зарим арга хэмжээний тухай

Хөгжлийн банкны тухай хуулийн 8.1, Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, 2011 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлж байгаа Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг 2016 онд багтаан дуусгах шаардлагатай байгааг харгалзан тус замын барилгын ажлыг 5 багц болгож, гүйцэтгэгч компаниудтай байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Зам, тээврийн сайд М.Зоригтод зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Авто замын барилгын ажлын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 185 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн “... ажлыг 2-3 багц болгон хувааж, техник, ажиллах хүчний чадавхи сайтай компанитай гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэхийг Зам, тээврийн сайд А.Гансүхэд зөвшөөрч,” гэснийг “ажлын” гэж өөрчилсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

М.ЗОРИГТ